

**СЭЛЭНГЭ АЙМАГТ 2017 ОНЫ 11-Р САРД ЗОХИОН БАЙГУУЛАХ  
НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2017.11.06

№	Хийгдэх ажил, арга хэмжээ	Хугацаа	Хэрэгжүүлэх хэлтэс, алба, газар	Хариуцах эзэн
<b>Нэг.Удирдлага зохион байгуулалтын хүрээнд:</b>				
1	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөвлөгөөнд тусгагдсан зарим асуудлыг боловсруулан хэлэлцүүлэх	Сардаа	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Ө.Сувдаа
2	Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, хугацаатай тайлан мэдээнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх журмыг боловсруулж батлуулах	Сардаа	Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс	Д.Лувсандагва
3	Сэлэнгэ аймгийн төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах журмыг боловсруулж батлуулах	Сардаа	Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс	Д.Лувсандагва
4	Аймгийн хэмжээнд төрийн захиргааны сул ажлын байрны захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, нөөцөөс нөхөх ажлыг зохион байгуулах.	Сардаа	Аймгийн Төрийн албаны салбар зөвлөл	Ө.Сувдаа
5	Хууль зүй, дотоод хэргийн сайдын аймгийн Засаг даргатай 2017 онд хамтран ажиллах талаар байгуулсан гэрээнд заасны дагуу хууль сахиулах аюулгүй байдлыг хангах албадыг түшиглэн “Команд штабын сургалт”-ыг зохион байгуулах	Сардаа	Хууль, эрх зүйн хэлтэс	Д.Ёндонжамц
6	Шинээр батлагдсан хууль тогтоомжийн агуулгаар иргэдэд зориулсан хялбаршуулсан нугалбар хуудас бэлтгэн түгээж, Түшиг суманд сургалт зохион байгуулах	11-р сарын 08, 25-ны өдрүүдэд	Хууль, эрх зүйн хэлтэс	Д.Ёндонжамц

7	Монгол Улсад орчин цагийн архивын салбар үүсэн байгуулагдсаны 90 жилийн ойн баярт зориулсан “Архивын хөгжлийн өнөө ба ирээдүйн чиг хандлага” сэдэвт сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулах	11-р сарын 24	Хууль, эрх зүйн хэлтэс, Архивын тасаг	Д.Ёндонжамц Б.Хишигням
8	Сумдын санхүүгийн боловсон хүчний нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэл, төрийн сангийн үйл ажиллагааны журам, зааврын талаар сургалт явуулж, нөөцөд бүртгэх	Сардаа	Санхүү, төрийн сангийн хэлтэс	М.Нарантуяа
9	Нягтлан бодогчдын мэргэжлийн тангараг өргөх ёслолыг зохион байгуулах	11-р сарын 16	Санхүү, төрийн сангийн хэлтэс	М.Нарантуяа
10	Шилэн дансны цахим хуудас дахь төр, төсвийн байгууллагуудын 3-р улирлын мэдээлэл байршуулалтанд аудит хийж, дүнг аймгийн ИТХ, Засаг даргын зөвлөлд танилцуулах	Сардаа	Санхүүгийн хяналт, аудитын алба	Б.Дарихжав
11	Эд хариуцагчдын сертификат олгох сургалтыг зохион байгуулах	Сардаа	Санхүүгийн хяналт, аудитын алба	Б.Дарихжав
12	Татвар ногдох зүйл, татвар төлөгчийн тооллогыг аймгийн хэмжээнд зохион байгуулах	Сардаа	Татварын хэлтэс	Х.Батболд
13	Монгол Улсад Статистикийн байгууллага үүсэн байгуулагдсаны 93 жилийн ойн хүрээнд ЕБС-н төгсөх ангийн сурагчдад “Статистикийн боловсрол” сэдвээр хичээл заах	11-р сарын 10	Статистикийн хэлтэс	Д.Гүндэгмаа
14	Худалдан авах ажиллагааны мэргэшсэн АЗ сертификат олгох сургалтыг зохион байгуулах	11-р сарын 3-7	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар	А.Эрдэнэгэрэл, П.Эрдэнэсайхан
<b>Хоёр.Нийгмийн салбарын хүрээнд</b>				
1	"Оны шилдэг илтгэл" шалгаруулах эрдэм шинжилгээний бага хурлын 2, 3 дугаар шатыг зохион байгуулах	11-р сарын 8	Боловсрол, соёл урлагийн газар	Ч.Жаргалсайхан
2	Хушаат сумын иргэдэд Сүрьеэгийн эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулах	Сардаа	Эрүүл мэндийн газар	Ж.Од
3	Дархлаажуулалтыг 10 хоногийн аяныг зохион байгуулах	Сардаа	Эрүүл мэндийн газар	Ж.Од

4	Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааны дахин үнэлгээний ажлын хүрээнд өргөдөл өгсөн өрхүүдээс судалгаа авах ажлыг зохион байгуулах.	Сардаа	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	Л.Зоригтбаатар
5	Аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн гишүүдийг чадвахжуулах, аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хөтөлбөрийн хэлэлцүүлгийн арга хэмжээг зохион байгуулах	Сардаа	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	Л.Зоригтбаатар
6	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд даатгуулагчдыг хамруулах ажлыг зохион байгуулах	Сардаа	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс	С.Отгонжаргал
7	Deaflympics Олимпийн аварга Монгол Улсын гавъяат тамирчин Дамдины Очбадралын нэрэмжит “Жү-до” бөхийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг Мандал суманд зохион байгуулах	11-р сарын 4-5	Биеийн тамир спортын газар	Б.Баттулга
8	Аймгийн Биеийн тамир спортын газрын түүхт 70 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах	11-р сарын 25	Биеийн тамир спортын газар	Б.Баттулга
<b>Гурав.Хөгжлийн бодлогын хүрээнд:</b>				
1	Хөрс, агаар орчныг бохирдуулж байгаа эх үүсвэрийн тоо бүртгэл явуулж, мэдээллийн сан бүрдүүлэх	Сарын турш	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	З.Түвшинтөгс
2	Уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөхөн сэргээлтийн ажлыг технологийн дагуу хийлгэж, биелэлтийг хангуулах арга хэмжээ авах	Сарын турш	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Байгаль орчин, аялал жуулчлалын газар	А.Эрдэнэгэрэл З.Түвшинтөгс
3	НҮБ-ын “UN-REDD” үндэсний хөтөлбөр, БОАЖЯ-тай хамтран “Ойн тогтвортой менежмент” сэдэвт сургалтыг аймгийн ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага, ойн ангиудыг хамруулан аймгийн төв Сүхбаатар суманд зохион байгуулах	11-р сарын 06, 07-ны өдрүүдэд	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	З.Түвшинтөгс
4	“Ойн нөхөрлөлүүдийн өнөөгийн байдал цаашид авах арга хэмжээ” сэдэвт сургалтыг сум дундын ойн ангиудыг түшиглэн зохион байгуулах	Сарын турш	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	З.Түвшинтөгс

5	Орон нутгийн өмчит байгууллагуудын 2014-2016 үндсэн хөрөнгийн тайланг "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем" программд шивж оруулах	Сарын турш	Орон нутгийн өмчийн газар	П.Эрдэнэсайхан
6	Бод малын ангилалтын тайланг нэгтэж, зохиомол хээлтүүлэгийн ажлыг орон нутагт зохион байгуулах	Сарын турш	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Б.Мөнхтөр
7	Мал амьтны эмийн тухай, эмийн зүйн зохистой хэрэглээний талаар малчид, иргэдэд сургалт зохион байгуулж, зөвлөмж танилцуулга бүхий гарын авлагаар хангах	Сарын турш	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Б.Мөнхтөр
8	Гидротехникийн барилга байгууламжууд болон шинээр байгуулах төв, цөөрмийн судалгааг авч, мэдээллийн сан үүсгэх, гадаргын усны нөөц бий болгох газрын судалгааг гаргах	11-р сарын 06-11	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	Б.Саруултөгс
9	Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 280 тоот тогтоолоор батлагдсан "Гудамж, зам талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам"-ыг үндэслэн шинээр байгуулсан суурин, хороолол, гудамж, зам, талбайд нэр, дугаар, хаяг өгч баталгаажуулах ажлыг зохион байгуулах	11-р сарын 06-11	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	Б.Саруултөгс

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР